

ОРШИЛ

Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших “Чулуут цагаан дэлийн зүүн салаа”-ны хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 150 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урд зүгт 117 км, Баянцагаан сумын төвөөс сумаас зүүн хойш 22 км-ийн зайд, Улаанбаатар - Замын-Үүд чиглэлийн төмөр замын Мааньт өртөөнөөс баруун урд зүгт 50 км-ийн зайд оршино. Ордын талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 100’000 масштабтай байр зүйн зургийн L-48-47 нэрлэбэртэй хавтгайд оршдог.

УУХҮЯ-ны дэргэдэх АМГТГ-ын Эрдэс Баялагийн Мэргэжлийн Зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Т/24-12-02 тоот дүгнэлт, АМГТГД-ын 2024 оны 05 сарын 20-ны өдрийн тушаалаар Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших MV-008595 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баян жонш” ХХК-ийн “Чулуу цагаан дэлийн зүүн салаа” нэртэй хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан.

Баянжонш ХХК нь Чулуутын зүүн салааны уурхайн 8595А тоот тусгай зөвшөөрлийг 2003 онд авч, 2010 онд анх ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, БОНБНарийвчилсан үнэлгээ боловсруулж баталгаажуулан, 2011 онд уурхайг улсын комисст хүлээлгэн өгсөн. 2014, 2022 онуудад ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-н тодотгол, БОНҮ, 2023 онд нөөцийн тодотгол хийж, 450 мян.тн хайлуур жоншны нөөц нэмэгдүүлэн баталгаажуулж. 2024 онд ЧЗС ордыг ил болон далд аргаар олборлох ТЭЗҮ-г боловсруулж баталгаажуулсан. Санхүү эдийн засгийн боломжоос шалтгаалан уурхайг ашиглахгүй, олборлолт явуулаагүй баясан бөгөөд 2024, 2025 онуудад уулын ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Энэ онд уулын ажлын бэлтгэл малталтууд эхлүүлсэн бөгөөд “Грийн солиушн консалтинг” ХХК-тай гэрээ хийж, БОНБЕрөнхий болон Нарийвчилсан үнэлгээ хийлгэж баталгаажуулсан.

2025 онд тус компани жилд 100 мянган тн хайлуур жоншны хүдэр ил ба далд аргаар олборлох уурхайг өөрийн хөрөнгөөр байгуулж, ашиглалтанд оруулж, улсын комисст хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ,

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр : Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших “Чулуут цагаан дэлийн зүүн салаа” нэртэй хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төсөл
- Төсөл хэрэгжүүлэгч: “Баян жонш” ХХК - Улсын бүртгэлийн дугаар: 9011105065 - Регистрийн дугаар: 2696304 - Тусгай зөвшөөрөл: MV-008595
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас ▪ Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 22-р хороо, Дүнжингаравын гудамж 48-р байр 2 тоот ▪ Утас- 70149001, 99112164
- Төслийн талбайн хэмжээ ▪ 89.3 га
- Газар зүйн байршил ▪ “Чулуут цагаан дэлийн зүүн салаа” нэртэй хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 150 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урд зүгт 117 км, Баянцагаан сумын төвөөс сумаас зүүн хойш 22 км-ийн зайд, Улаанбаатар - Замын-Үүд чиглэлийн төмөр замын Мааньт өртөөнөөс баруун урд зүгт 50 км-ийн зайд оршино. Ордын талбай нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 100’000 масштабтай байр зүйн зургийн L-48-47 нэрлэвэртэй хавтгайд оршино.
- “Баян жонш” ХХК-ийн Төв аймгийн Баянцагаан сумын нутагт орших MV-008595 “Чулуут цагаан дэлийн зүүн салаа” нэртэй хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан
- Төсөл боловсруулагч: “Грийн солюшн консалтинг” ХХК

1.2 Ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц

Ордын хэмжээнд анхны геологи, хайгуулын ажлыг 2008 онд хийж гүйцэтгэн хүдрийн 4, 7, 8, 10, 13-р биетүүдийг илрүүлэн нөөцийг 2009 онд батлуулсан байдаг. Хүдрийн 7-р биет дээр нэмэлт хайгуулын ажлыг 2022 онд гүн рүү өсгөх зорилгоор хийж гүйцэтгэн 2023 онд хүдрийн 7, 7а, 7б биетүүд болгон ялгаж нөөцийг батлуулсан байдаг. Иймд ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийхдээ ЭБМЗ-ийн 2009 оны 07-р сарын 08-ний өдрийн ХХ-17-05 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2009 оны 07-р сарын 24-ний өдрийн 308 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2023 оны 06-р сарын 08-ний өдрийн ХХ-07-07 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан УГА-ны даргын 2023 оны 08-р сарын 14-ний өдрийн Н/57

тоот тушаалаар тус тус батлагдсан геологийн нөөцөд тулгуурлан хийсэн. Уг батлагдсан геологийн нөөц нь бодитой (В) зэрэглэлээр 266.78 мян.тн хүдэр, 54.98%-ийн дундаж агуулгатай 146.68 мян.тн эрдэс, боломжтой (С) зэрэглэлээр 199.52 мян.тн хүдэр, 48.89%-ийн дундаж агуулгатай 97.54 мян.тн эрдэс, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 466.30 мян.тн хүдэр, 52.37%-ийн дундаж агуулгатай 244.32 мян.тн эрдсийн нөөцтэй байна.

1.3 Ил уурхайн хүчин чадал, ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадал эхний 2 жилд 100.0 мян.тн, дараагийн жилүүдэд 50.0 мян.тн хүдэр олборлоно. Ашиглалтын эхний 2 жилд ил болон далд уурхайн нийт хүчин чадал нь 100 мян.тн/жил байна. Ил уурхайн аргаар ашиглах нөөцийг эхний 2 жилд олборлож дуусгахаар төлөвлөсөн.

Ил уурхайн нээлт: Уурхайн нээлтийг хүдрийн 7, 7а, 7б биетүүдийг ашиглах 1-р ил уурхайн зүүн зүүн хойд хэсгээс гадаад траншейн нэвтэрч уурхайн нээлтийг хийнэ. Уурхайн нээлтийн үед 14.85 мян.м³ хөрс хуулж 3.64 мян.тн хүдэр олборлоно. Уурхайн нээлтээр 137 метр урт, 68 метр өргөн, 10 метр гүнтэй ил уурхайн ухааш үүснэ. Нээгч малталтыг нөөцийн блокийн 7-4В-ийн зүүн хойд хэсгээс эхлэн суналын дагуу чиглэлд зүүн урдаас баруун хойш чиглэлд X=5202113, Y=5202113 цэгээс эхлэн үржил шимт өнгөн хөрсийг 20 см хүртэлх зузаантайгаар хуулж эхэлнэ.

Ашиглалтын эхний жилд 1-р ил уурхайгаас буюу хүдрийн 7, 7а, 7б биетүүдэд олборлолт явуулах ба нийт 296.91 мян.м³ хөрс хуулалтын ажил хийж, 72.83 мян.тн хүдэр олборлоно. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 5.25 м³ /тн байна. Эхний жилд нийт уурхайн ашиглалтад өртөх талбайн хэмжээ 1.23 га, гадаад овоолгын ашиглалтад өртөх талбайн хэмжээ 4.18 га байна.

Хөрс хуулалтын технологи: Хөрс хуулалтын ажил нь үржил шимт хөрсийг урьдчилан хуулах болон үндсэн хөрсийг хуулах гэсэн үндсэн 2 шатлалтай явагдана. Нэгдүгээр үе шат: Уурхайн уулын ажлын ахилт, өрнөлтэй уялдуулан тухайн жилд ашиглалтад өртөх талбайн болон хөрсний гадаад овоолгод дарагдах талбайн өнгөн хөрсийг уг бүс нутгийн хөрсний шимт болон шилжилтийн үеийн зузаанаас хамааруулан 0.2 м метр хүртэлх зузаантайгаар хуулах бөгөөд уурхайн эцсийн хүрээний гадна талд салхины шууд нөлөөллөөс далд нөмөр газар овоолго үүсгэн хураана. Уг ордын уурхайн ашиглалтад өртөх талбайгаас нийт 4.90 мян.м³ шимт хөрсийг хуулна. Мөн үүнээс гадна үйлдвэрлэлийн зориулалтаар уурхайн болон зам талбай барилга байгууламжид өртөн эвдэгдэх талбайнуудын үржил шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар урьдчилан хуулж хадгална. Ингэж тусгайлан хадгалсан үржил шимт хөрсийг уурхайн үйл ажиллагаа дууссаны дараагаар уг эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажил хийхэд ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м байна.

Хоёрдугаар үе шат: Ил уурхайн хуулах хөрсийг өрөмдлөг, тэсэлгээгээр сийрэгжүүлнэ. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр нь 5 м байх бөгөөд ажлын доголын хажуугийн өнцөг нь тухайн доголын чулуулгийн тогтворжилтоос хамаарч 65-70 градус байна.

1.4 Далд уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц

Ордыг ил болон далд аргаар ашиглах бөгөөд далд уурхайн хүрээнд 199.02 мян.тн хүдэр, 52.16%-ийн дундаж агуулгатай 103.82 мян.тн эрдэс өртөж байна. Ашиглалтын үеийн хаягдал 4.43% буюу 8.81 мян.тн хүдэр, бохирдол нь 6.16% буюу 12.26 мян.тн хоосон чулуулаг байна. Ингэснээр далд уурхайн үйлдвэрлэлийн нөөц нь 202.47 мян.тн хүдэр, 49.16%-ийн дундаж агуулгатай 99.53 мян.тн эрдэс болж байна. Ордын хэмжээнд ил, далд аргаар ашиглах үеийн хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн үр ашигтай үйлдвэрлэлийн нөөц нь магадалсан (В') зэрэглэлээр 334.04 мян.тн, үйлдвэрлэлийн нөөц дэх CaF₂-ийн дундаж агуулга 50.44%, 168.47 эрдэс болж байна.

Далд уурхайн хүчин чадал: Далд уурхайн жилийн хүчин чадлыг эхний 2 жилд ил уурхайгаас олборлох хүдэртэй нийлээд 100.0 мян.тн хүрэх зорилтын дагуу эхний жилд 21.17 мян.тн, 2 дахь жилд 41.26 мян тн, 3 дахь жилээс төслийн бүрэн хүчин чадлаар 50.0 мян.тн хүдэр олборлохоор тусгасан.

Далд уурхайн ажиллах горим: Далд уурхай нь улирал харгалзахгүй уулын ажлыг баяр ёслолын өдөр, засвар үйлчилгээ, ажилчдын богино хугацааны амралтаас бусад үед тасралтгүй явуулна. Уулын ажлыг газрын дор ажиллах далд уурхайн хэсэгт 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөсөн.

Далд уурхайд орж ирэх газар доорх усны урсацын тооцоо Далд аргаар 70 м гүн хүртэл олборлолт явуулна. Тухайн ордын гидрогеологийн нөхцөл энгийн боловч олборлолт тодорхой түвшинд хүрэхэд уурхайд газар доорх усны урсац ан цавын сүлжээгээр шүүрч орох бөгөөд неопротерозойн настай чулуулгийн ан цавын коллекторт агуулагдах алаг цоог тархалттай газар доорх ус нь ан цав болон хагарал эвдрэлийн бүсийн сүлжээний гүний байрлалаас хамааран янз бүрийн гүний интервалаас илэрнэ. Хувирмал чулуулгийн экзогений гарал үүсэлтэй ан цавын сүлжээний тархалт нь гүний бүтэц болон талбайн хэмжээнд харилцан адилгүй жигд бус байдагтай холбоотойгоор ан цавын бүсэд агуулагдаж буй газар доорх ус нь нөөц баялгийн хувьд хязгаарлагдмал, алаг цоог тархалттай байна. Ордын газар доорх усны үндсэн нөөц, баялгийг бүрдүүлэгч өгөршил-ан цавын усажсан бүсийн алаг цоог тархалттай газар доорх ус нь алсын тэжээгдэлгүй, харьцангуй усжилт багатай учир олборлолтын үед онц хүндрэл учруулахгүй. Харин тектоник хагарлын бүсэд ан цавын харьцангуй өндөр усжилттай газар доорх усны голомт байж болохыг олборлолтын явцад анхаарах шаардлагатай.

Далд уурхайн ус шүүрүүлэх арга хэмжээ Уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад далд уурхайд орж ирэх усыг зайлуулах, уурхайн мөргөцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг далд уурхайн налуу амны тусламжтайгаар гүйцэтгэх болно. Далд уурхайн мөргөцгийн усыг зайлуулахдаа дренажийн сувгаар уурхайн мөргөцгийн хамгийн нам дор хэсэгт усыг зумпфэнд хуримтлуулан ус өргөх шахуургын (насос) тусламжтайгаар гүйцэтгэж байгаа бөгөөд насосын хүчин чадал нь 20.0 м3 /цаг болно. Уурхайн мөргөцөгт орж ирэх усыг дренаж ашиглан хамгийн нам доор хэсэгт байгуулсан зумпфэнд хуримтлуулан 20.0 м3 /цаг багагүй хүчин чадалтай 1 ш зөөврийн насосоор шавхаж байгаа бөгөөд усыг тусгай хоолой, сувгаар дамжуулан урсган гаргаж байгаа болно. Мөн уурхайн ашиглалтын үед уурхайн технологийн тээврийн зам, талбайг услахад уурхайгаас шүүрүүлж буй усыг үйлдвэрлэлийн болон байгаль орчин-геоэкологид эерэг нөлөө үзүүлэх зорилгоор ашиглах ба 2025 онд тус уурхайн ус хуримтлуулах санд мэргэжлийн байгууллагаар шавхалт хийлгэж ундрагыг тогтоолгосон ба энэхүү усны урсацыг Усны газраар дүгнэлт гаргуулан бусад далд уурхайн адил байгаль дэмий асгахгүйгээр, нуур байгуулж хуримтлуулан, уурхайн дэргэд орших Монголчехметалл ХХК-ийн Чулуут цагаан дэлийн хайлуур жоншны Баяжуулах үйлдвэрт ашиглах бөгөөд гүний цэвэр ус биш, далд уурхайн шүүрлийн усыг хэрэглэж, усны нөөцийг зөв зохистой ашиглах бодлогыг баримтлан ажиллах болно. Малталтаар шүүрүүлсэн гүний усыг үндсэн малталтаар дамжуулан налуу гол ам орчмын малталтад байрлах зумпфэнд цуглуулан ЦНС20-120 маркийн шахуургын тусламжтайгаар 89 мм-ийн диаметртэй төмөр ган хоолойгоор дамжуулан газрын гадаргууд гаргаж, хиймэл нуурт хуримтлуулна. Налуу ам орчмын малталтад хэвтээ түвшингээс доош 3 м суулгаж хэлбэржүүлэн ус цуглуулах зумпф үүсгэнэ. Зумпфны багтаамж нь 24 м3 багтаамжтай байна. Хоногт шүүрлийн ус хуримтлагдах хэмжээ нь тухайн ашиглалт явуулж буй түвшинд 0.003 л/с буюу хоногт 277.04 л ус шүүрэхээр байгаа учир зумпфны багтаамж хангалттай.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллүүд

1. Голын гольдролыг өөрчлөх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, ой модыг огтлох гэмтээх зэрэг бусад 10 асуудлаар ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байна.
2. Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээ, үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх гэх мэт 5 асуудлаар бага хэмжээгээр нөлөөлөл үзүүлнэ.
3. Дунд зэрэг өртөх 2 асуудлаар нөлөөлөлтэй байна.
4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаархи төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой шаардлага хангасан зэрэг 6 асуудлаар төслөөс их нөлөөлөлтэй байна.

Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Тус ордыг ашиглалтын тусгай зөвшөөрөл 89.3 га талбайг эзэмшдэг. Талбайн үржил шимт хэсгийг 20 см хүртэл зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах ба уурхайг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ. Эдгээр газар ашиглалтын хэсгүүдэд ашиглалтын тодорхой хязгаарлалтуудыг тогтоож өгснөөр газар ашиглалтаас үүдэн гарах газрын гадаргын өөрчлөлт, газрын эвдрэл зэргийг хянах зохицуулах боломж бүрдэнэ. Тус талбайн хувьд газрын гадаргын бага зэргийн эвдрэлтэй. Энэ нь бага хэмжээний талбайд гүнзгий ухаш, хайгуулын ажлын ул мөр, тээврийн хэрэгслийн мөр зэрэг эвдрэл үүссэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд

Ухаш олборлолт. Уурхайн үндсэн үйл ажиллагаа буюу олборлолт уурхайн хаш дотор явагддаг. Уулын цулыг утгуурт ачигч буюу экскаватороор тээврийн хэрэгсэлд ачихад хялбар болгохын тулд уурхайн хүдэр болон хөрсний биетэд өрөмдөж тэсрэх бодисоор тэсэлгээ хийнэ. Тэсэлгээгээр суларсан хөрс, хүдрийг тээврийн хэрэгсэлд утгуурт ачигчаар ачна. Өрөмдлөг, тэсэлгээ, ухаж ачих, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүснэ.

Овоолго үүсэх. Ухаш олборлолтоор тээврийн хэрэгсэл уулын цулыг уурхайн овоолго дээр тээвэрлэж буулгахад тээврийн хэрэгслээс овоолгод материал буулгахад болон овоолго үүсгэх автомеханизм болох утгуурт ачигчийн үйл ажиллагаар орчны агаарт тоос, тоосонцор ялгарна.

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг. Түлшний

найрлаганд агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч, дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхэрийн ислүүд, нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик, нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.

Уурхайн тээврийн замаас үүсэх тоосжилт. Сайжруулаагүй зам эсвэл замгүй хэсгээр тээврийн хэрэгсэл зорчих үед дугуйн даралтын хүчний үйлчлэлээр гадаргуун материал хэмхэрч нунтгардаг. Тээврийн хэрэгсэл зорчин өнгөрөх үед түүний ард дагалдан үүсдэг агаарын хүчтэй турбулент хөдөлгөөний үйлчлэлээр замын гадаргуун материалын эгэл хэсгүүд хөдөлгөөнд орох эргэлдэж буй дугуйгаар зарим хөрсний эгэл хэсгүүд дээш өргөгдөх болон зарим эгэл хэсгүүд доош унах зэргээр тоосжилт үүсдэг. Замын тухайлсан хэсгээс үүсэх тоосжилтын хэмжээ нь замын ачааллаас шугаман. замын гадаргын материалын шаварлаг агууламжаас шууд хамааралтайгаар өөрчлөгддөг. Уурхайн бүсэд хүнд даацын тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн үүсгэх тоосжилт нь тэдгээрийн жингээс нэлээд хамааралтай байдаг

Уурхайн өрөмдөг, тэсэлгээнээс үүсэх тоос. Уурхайд хийгдэх тэсэлгээ нь ашигт малтмал олборлоход зайлшгүй шаардлагатай технологи юм. Жилийн олборлох хэмжээнээс шалтгаалан тэсэлгээний давтамж болон хэмжээг тооцдог. Тэсэлгээнээс үүсэх агаар бохирдуулагч нь дэлбэрэлтээр агаарт цацагдсан хөрс, материалаас үүсэх тоосжилт болон тэсрэх бодист агуулагдах элементийн найрлага болон шаталтаас үүсэх азотын ислүүд, хүхэрлэг хий, нүүрстөрөгчийн дутуу исэл болон бусад хийнүүд агаарт ялгардаг.

Хөрсний бүрхэвчийн эвдрэл, талхагдал

Төслийн талбайд өнөөгийн байдлаар, ердийн шороон замын нөлөөгөөр 0.84 орчим га газар бага зэрэг талхадсан, технологийн зам талбай болон суваг шуудуунд өртөж бага зэрэг эвдэрсэн 5.2 га, уурхайн нөлөөлөлд өртөж хүчтэй эвдэрсэн 12.4 га тус тус байна. Эдгээр нь нийт төслийн талбайн 21% орчмыг эзэлж байна.

Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин: Хөрсөн дэх хортой хүнд металл гэдэгт дараах 6 элемент багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu) орно. Эдгээрээс Cd, Cr, Pb нь онцгой хортой, Cu, Ni, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Төслийн талбайгаас авсан дээжинд агуулагдах хүнд металлуудын агууламжийг харахад Судалгааны үр дүнг МУ-ын “MNS5850:2019 Хөрсний

чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандартад заасан хөрсний органик биш (хүнд металл) бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулахад: Хүнд металлын шинжилгээний үр дүнгээс үзэхэд өнгөн хөрсөн дэх Cd маш бага буюу бараг илрээгүй, бусад металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна

Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдал

Уг төслийн үйл ажиллагаанаас газрын доорх усанд нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл нь уурхайн ус шүүрэлтээс газрын доорх усны нөөц багасах нөлөөлөл байна.

- Ус ашиглалтаас үүсэх нөлөөлөл
- Уурхайн унд ахуй болон технологийн зориулалтаар ус ашиглалтаас газрын доорх усны нөөц болон уст үед тодорхой хэмжээний өөрчлөлт оруулна.
- Усны бохирдол- Уурхайн дотоод хяналт сулрах, санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар хөрсөнд шатах тослох материал болон хатуу хаягдлууд алдагдах нь хөрсөөр дамжин газрын доорх усыг бохирдуулах эх үүсвэр болж болзошгүй
- Ус шүүрүүлэлтээс дам нөлөөлөл үүсч болзошгүй

Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал

Ургамлын бүлгэмдэл, төрөл, зүйлийн бүрдэл: Ургамалжлын хувьд тэгш тал газар болон жигд өргөгдсөн тэгшивтэр газруудаар ихэвчлэн Шивээт хялганат хээр зонхилон тархах зүй тогтолтой юм. Зарим нам хотос хэсэгт мараа, хужиртай хөндий байрласан байдаг. Энэхүү хөндийн хамгийн нам газарт хөрсөн дээр сэвсгэр хужир ил гарсан байх бөгөөд зарим газар *Suaeda corniculata* тааралдана. Хужирлаг хөндийн төв хэсгээр захруугаа явах тусам Турьхан Ахар сорт Арвайт Улалжит бүлгэмдлүүд тохиолдоно. Тэрчлэн Дэрс бүхий Түнгэт бүлгэмдэл энэхүү хөндий зах сэжүүрийг эжээрлэн ургасан байдаг.

Төслийн талбай болон тухайн орчмын нутаг дэвсгэр нь ургамлын экологи, тархах ургамлан нөмрөгөөрөө хуурай хээрийн ургамалжилтай бөгөөд бүхэлдээ 3 хэв шинжид хамаарах 6 бүлгэмдэл тархсан байна. Тус талбай нь тэгш талаар хажуу хэсгээр тархах бөгөөд хуурай хээрийн үетэнт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 51%, 22 зүйлийн ургамал бүртгэгдсэн бөгөөд 1 м2 талбайд 12 зүйлтэй, ургац 2.5 ц/га байсан. Өвслөг ургамлын 10-15 см өндөртэй байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс шивээт хялгана, дэрвээн хазаар өвс, алаг өвснөөс бургас навчит банздоо, ширэг улалж, агь, ширэг улалж, имт гичгэн арзгар согсоолж ургана. Бэлчээрийн талхагдал байхгүй хашиж хамгаалсан.

Тус талбай нь эвдэрсэн газраар ургах бөгөөд цөөн наст бүхий алаг өвст бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 20- 50%, 17 зүйлийн ургамал бүртгэгдсэн, ургац 1,3 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 10 см. Зонхилогч ургамлын хувьд үетнээс хиаг, ногоон хоног будаа, алаг өвснөөс хөдөөгийн сэдэргэнэ, халгай, эмийн багваахай, имт гичгэнэ тохиолдоно.

Бэлчээрийн талхагдал байхгүй хашаалсан талбай байсан. Талбай нь байгалийн аясаараа нөхөн сэргэн нэг наст нь олон наст алаг өвсөөр солигдсон бүс нутгийн ургамлаас хиаг 10%, имт гичгэнэ 1% бүрхэцтэй ургаж байсан.

Төслийн талбайд кемп орныг тохижуулж ногоон байгууламж байгуулсан бөгөөд хайлаас 50см ургасан бөгөөд 50 см дээш өндөртэй дасан зохицож ургаж байна. согоовор тарьсан. Төслийн талбай өмнө нь бэлчээрээр ашиглагдаж байгаад одоо хашаалж хамгаалсан бөгөөд дунд зэргийн доройтсон ангилалд хамаарна.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Төслийн үндсэн талбай болох Төв аймгийн Баянцагаан сумын нутаг нь Хээрийн бүсэд хамрагддаг бөгөөд амьтдын тархалт, байршилт нь цөөн орчинд төвлөрсөн, алаг цоог байдалтай. Талбайн ихэнх хэсгийг тачир, сийрэг ургамалтай. Ийм орчинд амьтдын зүйлийн бүрдэл нэн цөөн. Харин энд байдаг уул хад, хайлаас, зэгс бүхий байгалийн задгай устай нуур, тогтоол устай газруудад цөлөрхөг хээрийн үндсэн амьтад орогнон байршиж, мөн нүүдлийн амьтад устай газраар дайран өнгөрдөг. Төв аймгийн өмнөд хэсгийн нутаг нь ус намгархаг газар, модлог ургамал багатай, тэгш талархаг тул шувуудын амьдрах орчин ядмаг газарт хамаарагдана. Тус аймгийн шувууны талаар хэвлэлийн мэдээ хомс, бага судлагдсан. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүн машин техникийн хөдөлгөөн нэмэгдэж, уурхайн олборлолтын үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад техногенезийн стресс үүсэх, уурхайлалтаас үүсэх тоосжилтоос ургамлан бүрхэвч сийрэгжиж хөрсний үржил шим буурснаар амьдрах орчин хумигдана. Дээрх сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээших нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах ба энэ явцдаа тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад амьтдын идэш болох зэрэг хорогдол гарч болзошгүй. Иймд уурхайн үйл ажиллагааг дээрх нөхцөл байдалтай уялдуулан нарийн төлөвлөх, орон нутгийн амьтан хамгаалах малчдын нөхөрлөлтэй хамтарч ажиллах шаардлагатай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь :

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Иймд уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр хязгаарлах нь нутгийн газар хөрс, ургамал амьтдыг хамгаалах арга хэмжээ болно. Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтдын зүйлийн тоо өсөх магадлалтай.

БҮЛЭГ 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Ил болон далд уурхайн аргаар хайлуур жонш олборлоход их хэмжээний тоос гаргах нөхцөл бүрддэг. Хөрсөнд өрөмдлөг, тэсэлгээний арга хэрэглэх мөн экскаватор, бульдизероор хөрсийг хуулах, овоолго хийх, ачих бутлах зэрэг технологийн процессийн явцад хуурай салхитай говийн нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

Тоосжилтыг бууруулах арга хэмжээ

- Гадаад дотоод тээврийн замыг хайрган хучилттай болгох
- Орчны тоосжилтод байнгын хяналт тавьж, тоосжилтыг бууруулахын тулд салхи ихтэй, хуурайшилттай үед зам талбайг чийглэж услана
- Уурхай, овоолгод өртөх талбайн үржил шимт өнгөн хөрсийг 0.2 м зузаан хуулж овоолго хийж, шимт хөрсний овоолгыг ургамалжуулан хамгаалаж, шимт хөрсний чанарыг алдагдуулахгүй байх
- Тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоог тогтмол хийж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, техник тоног төхөөрөмжийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж байна,
- Замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах, тоос босгохоос сэргийлж тээврийн хэрэгслийн хурдыг зохицуулах, хурдны хязгаарлалт тогтоох.
- Тэсэлгээ хийхэд агаар бохирдуулагч хий тархах радиусаас ажилчдыг гаргаж, сарнисны дараа талбайд нэвтрүүлнэ
- Уурхайн талбайг тойрсон хашаа, хаалт хамгаалалт хийж, олон салаа зам гаргахгүй
- Авто замын хажуугаар болон салхины зонхилох чиглэлд мод бут суулгац тарих зэргээр салхины хүчийг бууруулах арга хэмжээ авна
- Кемпийн гадаад орчныг зүлэгжүүлж, технологийн замыг хайрган хучилтаар хучина
- Ажлын бүсийн орчин дахь тоосжилт их байх нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй тул тэднийг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр хангана
- Салхи, шуурганд амархан хийсч орчны агаар, хөрсийг бохирдуулж болзошгүй цемент, шохой болон бусад хуурай нунтаг барилгын материалуудыг битүү сав, контейнерт хадгалах, хүчтэй салхи шуургатай үед салхинд хийсч тоосжилт үүсгэхээс сэргийлэх
- Хөрс хуулалт, тэгшилгээ хийх үед оновчтой тогтоосон технологийн горимыг баримтлах

Дуу шуугианыг бууруулах арга хэмжээ

- 1000 Гц-ийн давтамжтай 85дБА шуугиантай орчинд өдрийн 8 цаг ажиллахад хүний чихний сонсголд хортой нөлөө үзүүлдэг тул ийм байдал гаргахгүйгээр үйлдвэрлэлийн ажлыг зохион байгуулах

- Сонсголыг хамгаалах нийлэг бөглөө 10-20 дБА, чихэвч 20-40 дБА нь дуу шуугианыг багасгаж чаддаг тул хамгаалах хэрэгслийг шуугиан ихтэй газарт ашиглах замаар ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх

Хөрс, газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Газрын гадарга элэгдэл эвдрэлд өртсөнөөр хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөг, амьтны амьдрах орчин, аюулгүй байдал, агаарын тоосжилт гээд байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам байдлаар нөлөөлөл үзүүлдэг. Иймд:
- Төслийн үйл ажиллагаанаас шууд нөлөөлөлд өртөх газрын гадаргын шимт хөрсийг хуулж, MNS 5916:2008 стандартын дагуу хадгална
- Уурхайн хүрээг тойруулан мал, амьтан орж осолдохоос сэргийлж хашаа хамгаалалт хийнэ
- Шимт хөрсний түр овоолгыг хэлбэржүүлэн олон наст ургамлаар нөхөн сэргээж хамгаална
- Газрын гадаргад хөрсний овоолгыг MNS 5917:2008 стандартын шаардлагын дагуу налуулан хэвгийжүүлж нөхөн сэргээлт хийнэ
- Ил уурхай болон бусад байгууламжуудыг үерийн уснаас хамгаалах суваг шуудуу хийж, төсөл хэрэгжиж дууссаны дараа нөхөн сэргээлт хийнэ
- Уурхайд орж гарах замыг тэмдэгжүүлж, зөвхөн тогтсон мартшрутын дагуу зорчуулах, олон салаа зам гаргахгүй
- Засварын газар, шатахуун түгээх гадрын талбайг хатуу хучилттай болгох
- Хотхоны хогийн цэгийн суурийг хатуу хучилттай болгож, хог хаягдлаас үүсэх бохирдол хөрсөнд шууд нэвчихээс сэргийлэх

Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Далд уурхайн шүүрэлтийн усны тоо хэмжээгээр усны нөөц ашигласны төлбөрийг цаг хугацаанд нь төлөх,
- Ус ашиглах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглох
- Өөрийн талбайд байрлах гүний худагт усны чанарын шинжилгээг хийлгэж, түвшинг хэмжих
- Уст цэг, худгуудын усны түвшингийн хэмжилт, шинжилгээний үр дүнг мониторингийн журналд хөтлөх, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж байх
- Усны хэрэглээг нарийвчлан тогтоох, усыг хэмнэлттэй ашиглахын тулд цэвэр усны шугамын оролт, гаралт тухай бүрт тоолуур суулгуулж баталгаажуулалт хийлгэх
- Ил уурхайд үерийн уснаас сэргийлэх далан барих

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

- Ажилчдын хотхон болон төслийн талбайгаас ашиглагдахгүй бусад талбайнуудыг зүлэгжүүлж ургамалжуулах
- Төсөл хэрэгжих явцад төлөвлөсөн биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж байх

- Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Ногоон байгууламжинд тухайн орон нутгийн унаган ургамал, мод бутыг ашиглах, ургах чадвар сайтай, нөхөн сэргээлтэнд ашиглах боломжтой нутгийн ургамлуудыг сонгон үрийн нөөц бэлтгэх
- Хөрс хуулах, ургамлан нөмрөг талхлах газрыг аль болохоор бууруулах арга хэмжээ авна
- Ургамал нөмрөгийн нөхөн сэргээлтийн ажлыг явуулахдаа байгалийн аясаар нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт хийх тохиолдолд мэргэжлийн байгууллага, хүмүүсийн заавар зөвлөгөөний дагуу явуулах, харь зүйлийн ургамлын үр суулгац суулгахыг хориглоно
- Нөхөн сэргээлт хийхдээ тухайн экосистемийн ургамлын үрийг байгалиас бэлдэж зуны бороо угтуулах тарих

Амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруудах арга хэмжээ

- Олборлолтын талбайн орчимд ан амьтныг зориуд үргээхгүй байх, тэдний ус бэлчээр дундуур маршрутын бус замаар зорчихгүй байх, талбайн орчимд ил задгай хог хаягдал хаяхгүй байх, талбайн орчимд буу зэвсэг авч явах, ан амьтан агнахыг хатуу хориглоно
- Шаардлагагүй нүх, суваг шуудууг хашиж хамгаалан амьтан унаж осолдохоос хамгаална
- Ойр орчимд нутагладаг айл өрхийн мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх асуудалд анхаарах. Тухайлбал, уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоосжилтын хэмжээг багасгахын тулд зам талбайн усалгааг хийх
- Уурхайн ашиглалтын үйл явцтай зэрэгцүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, амьтдын унаган амьдрах орчныг бүрдүүлэх
- Барилга байгууламжид шувууд болзошгүй тул үүрлэх боломжтой хэсгүүдийг бөглөх,
- Олборлолтын талбай дахь байгууламжийн ашиглалтын хугацаанд машин техникийн дуу чимээ, агаарын бохирдол, технологийн болон ахуйн хог хаягдлыг багасгах

Нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хайлуур жоншны ордын үйл ажиллагаанаас нийгэм эдийн засаг, орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Орон нутгийн иргэдийг шаардлагатай ажлын байранд сургаж дадлагажуулан ажилд авах
- Орон нутгийн төсөвт оруулах хөрөнгийн хэмжээг: жил бүрийн 1-р улиралд багтаан Хамтран ажиллах гэрээг хийж, өмнө оны үйл ажиллагаа гэрээг дүгнэх
- Малын бэлчээрийн газрыг талхагдалд оруулахаас сэргийлэх, уурхайн хашаанаас гадна өрөмдлөг, хайгуул, олборлолт явуулсан бол тухайн газруудыг нөхөн сэргээх

Байгаль орчны удирдлага, зохион байгуулалт, бусад арга хэмжээ

- Нөхөн сэргээлтийн ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг тухай бүр зохион байгуулах

- Ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний элэгдэл, усны горим, нөөцийн байдалд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хяналт тавих
- Байгаль орчныг хамгаалах, түүний биелэлтэнд хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг аль нэг инженер техникийн ажилтанд хариуцуулах, Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтан нь ерөнхий инженерийн шууд удирдлаганд ажиллах
- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулана

Хог хаягдлын менежмент

Ахуйн хог хаягдлыг: цэвэрлэн ангилан ялгаж шатааж, устгалд ороогүй хог хаягдлыг хогийн цэгт битүүмжлэл сайтай хурааж ариутгаж, 20 тн хэмжээнд хүрэхээр Баянцагаан сумтай байгуулсан Хог хаягдлын гэрээний дагуу сумын зөвшөөрөгдсөн хогийн цэгт өөрсдийн техникээр тээвэрлэж хүргэнэ.

Үйлдвэрийн хог хаягдал дахин ашиглах боломжтой шил сав, лааз, цаас гэх мэтийг ангилан ялгаж, хоёрдогч түүхий эд авах цэгт тушааж борлуулна.

Шингэн хаягдлыг 70м3, 60м3, 50м3 багтаамж бүхий бетонон ёмкомт/танк/ үүсгэж хуримтлуулж бохирыг эзэлхүүний 60%-д хүрэхээр соруулан тээвэрлэж, Багахангай дүүргийн хаягдал цэвэрлэх байгууламжинд хүргэнэ.

Аюултай хог хаягдлыг: Төсөл хэрэгжүүлэгч нь аюултай хог хаягдлыг 180 хоног хүртэл хугацаанд эх үүсвэр дээр түр тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгалж болно /тухайн уурхайн хувьд автомашины тос маслын шүүр, тос маслын сав, хуванцар, ажилласан тос масло, автомашины дугуй гм/

- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий ажилтантай байх

- Аюултай хог хаягдлын нь хадгалах хашаа агуулах сав нь “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байх

- Аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах гал унтраах хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангана “Аюултай хог хаягдал зайлуулах гэрээ”-г БОАЖЯ-ны тусгай зөвшөөрөлтэй “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулж уурхайн машин техникийн аюултай хог хаягдал, дугуй, шүүр, тос тосолны сав зэрэг бүх хог хаягдлыг “Түмэн эгшиг” компанийн Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших аюултай хог хаягдал устгах, саармагжуулах үйлдвэрт устгалд оруулна.

БҮЛЭГ 4. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛТ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ

БОНБУ тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар дүйцүүлэн хамгаалах аргачлалыг баталсан байдаг. ЗГ-мөрийн хөтөлбөр: Уул уурхайн нөлөөллийг бууруулахад “Дүйцүүлэн хамгаалах” механизмыг нэвтрүүлнэ. БОНХС-ын 2015.01.06-ны өдрийн А-04, А-05 тоот тушаалууд “БОХ, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”, ”БОМТ боловсруулах, хянан батлах тайлагнах журам” зэрэг эрх зүйн актаар зохицуулагдана.

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний аргачлал: Дүйцүүлэн хамгаалах ажлыг дараах 6 үе шатаар төлөвлөн хэрэгжүүлдэг.

1. Нөлөөллийн хэмжээг тогтоох

1 Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох

3 Дүйцүүлэн хамгаалах газрын байршлыг тогтоох

4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх, дүйцүүлэн хамгаалах хугацааг нөлөөлөл үргэлжлэх хугацаатай харьцуулж тогтоох, урт хугацааны хамгааллыг хангах зарчмуудыг баримтлах шаардлагатай. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлоход Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоох: Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээний талаарх суурь мэдээллийг БОННУ-ний тайлангаас аргачлалыг мөрдлөг болгоно.

Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтээр 2025 онд: орон нутгийн ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянцагаан сумын 1-р багийн нутагт орших Өлзийт нуурын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэж, зайлуулна.

“Чулуут цагаан дэлийн зүүн салаа”-ны хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, экологид учирч болзошгүй Эрсдлийн үнэлгээний хамрах хүрээ

- Хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийн үнэлгээ

- Хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх эрсдлийн үнэлгээ

- Хайлуур жоншны орд ашиглах төслийн үйл ажиллагааны үед гэнэтийн аюул осол, аюулын эрсдэлийн үнэлгээ

Хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үзүүлэх эрсдэл

Хүний эрүүл мэндэд үзүүлэх байгаль орчны эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ боловсруулах арга зүй нь ижил байдаг. Энэ нь асуудлыг тодорхойлох, өртөлтийг тодорхойлох, хоруу чанарыг тодорхойлох эрсдлийг тодорхойлох гэсэн үндсэн үе шатуудаас бүрдэнэ

Төслийн зүгээс хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан ажилласан тохиолдолд учруулах эрсдэлийн магадлал бага байж болох юм. Харин эрсдэл үүссэн тохиолдолд учрах эрсдэлийн түвшин өндөр байж болох ба тооцоологдоогүй дам байдлаар хүний эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй юм.

Гэнэтийн аюул осол, эрсдэл, байгалийн гэнэтийн үзэгдэл, түүнтэй холбоотой эрсдэл

Үер: Хүчтэй аадар борооны улмаас төсөл хэрэгжих газарт үер болон уруйн үер буух магадлал бага зэрэг эрчмийн хувьд боломжтой байна.

Хүчтэй салхи шуурга: Төслийн бүс нутаг Монголдоо салхи ихтэй нутагт хамаарах бөгөөд жилийн дундаж салхины хурд 3.6м/с орчим, салхи шуурга харьцангуй их байна. Төслийн районд жилдээ 2.1 орчим өдөр цасан шуургатай, 22 өдөр шороон шуургатай байна.

Аянга цахилгаан: Төслийн районд жилдээ 23 өдөр бороо ордгийн дотор дунджаар 4.5 өдөр нь 6.1 мм-ээс их бороо орох боловч дулаан улирлын хур тунадасны 70 шахам хувийг энэ хэмжээний хур тунадас эзэлдэг. Жилд дунджаар 14.4 өдөр аянга цахилгаантай, хамгийн олондоо 26 өдөр хүрч байсан. Аянгатай бороо 7 дугаар сард хамгийн удаан үргэлжилдэг ба аянгатай борооны 54.8 хувь нь 30 минутаас 2 цаг орчим үргэлжилнэ.

Ажиллагсдын санамсар болгоомжгүй үйлдэл: Сogтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хүнд даацын тээврийн хэрэгсэл, машин механизм жолоодон осол гаргах, ажиллагсад архи дан согтуурсан үедээ хоорондоо маргалдан зодолдох, улмаар хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах нөлөөлөл гарах магадлалтай. Иймд ажлын дотоод журамд согтууруулах ундаа болон бусад мансууруулах бодисыг хэрэглэхгүй байх, хэрэглэсэн тохиолдолд ажилд гаргахгүй байх зэрэг журмыг дотоод дүрэмдээ тусгана

Хөдөлмөр хамгаалал хангагдаагүйн улмаас үүсэх хохирол: Аливаа үйл ажиллагаа, ажил эрхлэх явцад хөдөлмөр хамгаалал хамгийн эхэнд тавигдах асуудал юм. Хөдөлмөр аюулгүй ажиллагаа сайн байснаар тэр хэмжээгээрээ ажлын бүтээмж нэмэгдэнэ. Хэт их дуу чимээтэй орчинд сонсгол хамгаалах хэрэгсэлгүйгээр эсвэл уртасгасан цагаар ажиллах, машин техниктэй удаан харьцсанаас анхаарал болгоомж сулрах, улмаар ухааш нүхэнд унаж бэртэх,

машин техникт дайруулах зэрэг осол гарах магадлалтай. Ордыг ашиглах явцад хүнд машин механизмыг ашиглах бөгөөд үүнээс дуу чимээ ихээр ялгарна. Иймд хөдөлмөр аюулгүй байдлыг хангах үүднээс сонсгол хамгаалах хэрэгсэл болон бусад хувийн хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангана.

Техник технологи, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэл, осол: Уурхайн ажлыг гүйцэтгэх үед техникийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг санаатайгаар зөрчих, техник тоног төхөөрөмжийн буруу ажиллагаа, ажиллагсдын санамсар болгоомжгүй үйлдэл, ажлын байрны сахилга бат алдагдах зэргээс үүдэн эрсдэл аюул, осол учирч болзошгүй.

Аваар ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Уурхай нь өөрийн онцлогт тохирсон “Аваар устгах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу боловсруулсан батлуулсан “Аюулын үед хэрэгжүүлэх аваар устгах төлөвлөгөө”-тэй байх ба төлөвлөгөөг төсөл хэрэгжихээс өмнө боловсруулж, УУАА-аар хянуулж мөрдөнө. Төлөвлөгөөнд дараах арга хэмжээнүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

- Ил уурхай дээр гарч болзошгүй аваар осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөл (гал түймэр, усны аюул гэх мэт)-үүд тэдгээрийн байрлал, гарч болох газар
- Аваар осолд нэрвэгдсэн хүмүүсийг аврах арга хэмжээ
- Аваар ослыг гарсан даруйд нь буюу эхний үе шатанд устгах арга зам, аваар ослын үед инженер техникийн болон бусад ажилтны ажил, үүргийн хуваарь, зохион байгуулалт
- Аваар осол устгах ба хүмүүсийн амь насыг хамгаалах, аврахад зориулсан хамгаалах баг, хэрэгслийн байрлал, тоо хэмжээ
- Осол аваар гарсан үед уул уурхайн аврах аобаны аврагч, аврах ажлыг зохион байгуулах ажилтан нарны ажил, үүргийн хуваарь, аврах ажиллагаа зэрэг болно.

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

